



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/144

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 тогтоол, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06 дугаар “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 9-т тусгагдсан Зураг төсвийн зардлаас Өвөрхангай аймгийн “Эдийн засгийн хөгжлийн загварчлал” боловсруулахад 36,000,000 (гучин зургаан сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

3. Дээрх зардлыг “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолын 4 дүгээр хавсралтын 9-т тусгагдсан Зураг төсвийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0246

D:My Doc. Zahiramj. Zasag darga